

ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Цогтцэций сумын ЭМТ-ийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ӨМА-2022/130/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.Umnugovi@audit.mn Өмнөговь аймаг Даланзадгад сум 2022 он	Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: С.Цэрэнбаяр Утас: 70533539 Цахим хаяг: Tserenbayars@audit.gov.mn Аудитын менежер: Т.Хонгорзул Утас: 70533552 Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn Ахлах аудитор: Д.Сүрэнжаргал Утас: 70533552 Цахим хаяг: Surenjargald@audit.gov.mn
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу



**ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: umnogovi@audit.gov.mn

ЦОГТЦЭЦИЙ СУМЫН ЭМТ-ИЙН ДАРГЫН
ҮҮРГИЙГ ТӨЛӨӨЛӨН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ
Б.АМАРТҮВШИН ТАНАА

2022.02.22 № 123
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Цогтцэций сумын ЭМТ-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Цогтцэций сумын ЭМТ-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний байгууллагаас цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бэлтгэн нийлүүлэгч байгууллагаас 1,550,511,709.7 төгрөгийн эм хүлээн авахдаа бараа материалын тайлан, орлого, зарлагын баримт үйлдээгүй байгаа нь иж бүрэн байх, тасалбар болголт, толилуулга, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй. Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

016001031

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



С.ЦЭРЭНБАЯР

Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

/сая төгрөгөөр/

	Үзүүлэлт	2021.12.31
	Эргэлтийн хөрөнгийн дүн	430.9
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	5,895.9
	Нийт хөрөнгийн дүн	6,326.9
	Нийт өр төлбөрийн дүн	0.6
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	6,326.3
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	6,326.9
Санхүүгийн үр дүнгийн тайлан		
	Үйл ажиллагааны орлогын дүн	3,677.8
	Үйл ажиллагааны зардлын дүн	2,930.0
	Үйл ажиллагааны үр дүн	747.8
	Үйл ажиллагааны бус үр дүн	
	Үйл ажиллагааны нийт үр дүн	747.8
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан		
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,578.4
	Тайлант оны үр дүн	747.7
	Эцсийн үлдэгдэл	6,326.2
Мөнгөн гүйлгээний тайлан		
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	1,730.5
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	1,720.0
	Үйл ажиллагааны ЦМГ	10.5
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	-5.5
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	5.5
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	5.5
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	5.5
Төсвийн гүйцэтгэлийн тайлан		
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	1,229.7
	Урсгал зардал	1,229.7
	Хөрөнгийн зардал	0
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	
	Орон нутгийн төсвөөс	97.9
	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,120.4
	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	14.1
	Төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос	

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Цогтцэций сумын ЭМТ-ийн эрхэм зорилго нь: “Нарийн мэргэжлийн тусламж үйлчилгээг олон чиглэлээр чанартай хүртээмжтэй үзүүлдэг, өндөр ур чадвартай туршлагатай, мэдлэгтэй эмч мэргэжилтнүүдтэй орчин үеийн багаж тоног төхөөрөмжөөр хангагдсан иргэн бүрд ээлтэй, эвсэг найрсаг хамт олныг бүрдүүлсэн, улсын жишигт нийцсэн нэгдсэн эмнэлэг болоход оршино” гэж тодорхойлжээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг дараах хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын тухай хууль;

- Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалаар батлагдсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар” хүчингүй болж, 2021 оны 190 дүгээр тушаалаар шинэчлэн батлагдсан тушаалыг тайланд онд шинээр мөрдөгдөж байна.

Гурав. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй байна.

Дөрөв. Аудитын гол асуудал

Бэлтгэн нийлүүлэгч байгууллагаас 1,550.5 сая төгрөгийн эм хүлээн авахдаа бараа материалын тайлан, орлого, зарлагын баримт үйлдээгүй байна.

Тав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийсэн бөгөөд нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгаж тусгасан болно.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны нэгдсэн www.shilendans.gov.mn цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 787.7 сая төгрөгийн 107 мэдээллээс 94 мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн, 13 мэдээлэл буюу 40.6 сая төгрөгийн мэдээллийг мэдээлээгүй, хугацаа болоогүй 2 мэдээлэл байна.

Зургаа. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Эмийн нэр төрлийн гаргаж, хэвшүүлэх.

Долоо. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 2,720.4 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 1,169.8 сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 1,550.5 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүллээ.

7.1 Залруулсан алдаа

Эмийн тайланд үнэгүй орлого 1,169.7 сая төгрөгийг хандиваар бүртгэснийг залруулж, бусад дансаар бүртгүүлсэн.

7Албан шаардлага

1. Бэлтгэн нийлүүлэгч байгууллагаас 1,550.5 сая төгрөгийн эм хүлээн авахдаа бараа материалын тайлан, орлого, зарлагын баримт үйлдээгүй байгаа нь НББ-ийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "үнэн зөв байх", 13 дугаар зүйлийн 13.7 "анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

2. Шилэн дансны мэдээллийг харилцахын гүйлгээтэй тулган баталгаажуулахад 13 мэдээлэл буюу 140.7 мянган төгрөгийг мэдээлээгүй нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4 "таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг" дахь заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1				1		
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1				1		

7.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

[illegible]

[illegible]